

**ОХУ БА МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХ ХАРИЛЦААНЫ ЗАРИМ
АСУУДАЛД**

Т.МӨНХ-ОРГИЛ

Доктор (Ph.D.)

*Батлан Хамгаалахын Эрдэм Шинжилгээний
Хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан*

Д.Батбаяр

Докторант

*Батлан Хамгаалахын Эрдэм Шинжилгээний
Хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан*

Оршил

Бүс нутгийн төдийгүй олон улсын аюулгүй байдлын орчинд тодорхой хэмжээний чиг хандлага, байр суурийг тодорхойлж байдаг хойд хөршийн батлан хамгаалах үйл ажиллагааны бодлого бидний зайлшгүй анхаарал хандуулах асуудлын нэг юм. Учир нь одоо ч гэсэн зарим судлаачид Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зарим асуудалд ОХУ-ын байр суурь чухал гэж үзсээр байна. Тиймээс олон улсын тавцанд эдийн засаг гэхээсээ илүүтэйгээр батлан хамгаалах салбарын үйл ажиллагаагаараа давамгайлах байр суурийг илэрхийлдэг ОХУ-ын батлан хамгаалах бодлогыг тасралтгүй судлан шинжилгээ хийж байх нь бидний хувьд чухал юм.

Олон улсын харилцааны хүрээнд Монгол Улсын аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг төрийн албан ёсны баримт бичгүүдэд хөрш орнуудтай сайн хөршийн найрсаг харилцаа, бүх талын хамтын ажиллагааг эрхэмлэж “ОХУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээний заалт, үзэл санааны дагуу бүх салбар чиглэлээр өргөтгөн хөгжүүлнэ” гэж Монгол Улсын Засгийн газрын хөтөлбөрт тусгасан бол ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путин Монгол-Оросын сайн хөршийн харилцааг харилцан туслах, хамтран ажиллах олон жилийн бат зузаан уламжлалын үндсэн дээр сэргээн хөгжүүлэх сонирхолоо илэрхийлэн “Оросын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд танай орон онцгой байр суурь эзэлдэг” гэж цохон тэмдэглэсэн байна. Үүнээс харахад хоёр орны төрийн дээд түвшинд хөгжлийн бүх чиглэлээр хамтран ажиллах сонирхол байгаа нь улс төрийн болон эдийн засгийн хамтын

ажиллагааг өргөжүүлэх боломж байна. Монгол Улсын хувьд ОХУ-ыг ах дүүсийн барилдлагатай гэж халуун дотно хүлээн авдаг нь эдийн засаг төдийгүй улс төрийн хувьд таатай орчинг бий болгож харилцан итгэлцлийг бэхжүүлж байдаг билээ.

Үндсэн хэсэг

Монгол-Оросын дипломат харилцаа олон мянган жилийн түүхэнд суурилагдах онцлогтой билээ. Хоёр улсын дипломат харилцаа нь улс төр, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, цэрэг батлан хамгаалах зэрэг нийгэм эдийн засгийн бүхий салбарыг хамарч иржээ. Иймээс энэхүү илтгэлийн хүрээнд Монгол Улс болон ОХУ-ын цэрэг улс төрийн хамтын ажиллагааны зарим түүхэн асуудлыг товч авч үзье.

1917 онд Орос оронд ялсан Аугаа их Октябрын социалист хувьсгал олон зуун километр хил залгасан Монгол оронд нөлөөлж Зөвлөлт засгийн газраас 1918 оны 3 дугаар сард Богд Хаант Монгол Улсын засгийн газарт Монголд суух ажилчин тариачны шинэ төрийн элчин консул томилсоныг мэдэгдэж тэгш эрхтэй харилцаа тогтоох санал тавьсан байдаг. Энэ үед манай улсад Хятадын цэргийн дэглэм тогтож, 1920 оноос Оросын цагаантны харгислал ширүүсэж олон жил гадны дарлалд туйлдсан ард иргэдийн амьдрал туйлдаа хүрч байлаа. Энэхүү гадаад, дотоодын нийгэм улс төрийн тогтворгүй байдлаас үүдэн Монголд хувьсгалын тохироо бүрдэж эхэлсэн төдийгүй Монголын хувьсгалчид Нийслэл хүрээнд байсан Оросын хувьсгалчидтай холбоо тогтоосон нь хоёр орны цаашдын харилцаа, хамтын ажиллагааны суурийг тавьсан гэж үзэж болох билээ.

Монголын орчин үеийн улс төрийн анхны байгуулал болох Монгол Ардын Нам 1920 оны 4 дүгээр сарын 25-нд байгуулагдаж Зөвлөлт Орос улсаас цэрэг, зэвсгийн тусламж авч гадаадын эзлэн түрэмгийлэгч нарын эсрэг тусгаар тогтнол, үндэсний эрх ашгийг сэргээн бэхжүүлэх тэмцлийг эхлүүлсэн байдаг. 1921 оны 3 дугаар сарын 1-нд Монгол Ардын анхдугаар нам хуралдаж Зөвлөлт Орос улсын төрийн удирдагч нартай холбоо тогтоож тэдний тусламжтайгаар 1921 оны 6 дугаар сард Монгол Ардын журамт цэрэг, Зөвлөлтийн улаан армийн цэргүүд Нийслэл хүрээг цагаантуудаас чөлөөлж ардын хувьсгалыг амжилттай явуулж ялалт байгуулсан байдаг. Энэхүү Монгол Оросын цэрэг улс төрийн хамтын ялалтын дараа 1921 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр “Монгол, Оросын хоорондох найрамдлын барилдлагааг байгуулах тухай Монголын Ардын Засгийн газар ба Зөвлөлтийн Засагт Орос Улсын Засгийн газрын хэлэлцэн тогтоосон гэрээ бичиг” байгуулсан нь өнөөгийн дипломат харилцааны суурийг тавьсан нэн чухал алхам болсон.

Энэхүү Гэрээ бичиг нь Ардын эрхэт Монгол Улс, ЗСБНХОУ-ын хооронд шинэ харилцааг тунхаглаж хоёр орны хоорондын улс төр, эдийн засаг, соёлын харилцаа бүрэлдэн тогтох үндсийг бий болгосон байна. Гэрээ бичгийн хүрээнд хөдөө аж ахуй, харилцаа холбоо, эрүүлийг хамгаалах, соёл боловсрол зэрэг олон салбарт

ЗХУ-аас тусламж авахаас гадна цэрэг батлан хамгаалах болон эдийн засгийн салбарт маш олон чухал хамтын үйл ажиллагааг эхлүүлсэн. Цаашлаад Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах олон асуудлыг шийдвэрлэх эрх зүйн баримт бичгийн суурь болсон билээ.

Энэ үед мөн олон улсын хэмжээнд аюулгүй байдлын асуудлууд эрчимтэй өрнөж эхэлсний нэг нь улс орнуудад колончиллын болон феодализмын эсрэг үймээн, бослого хөдөлгөөн өрнөж, Ази болон Европ дах зарим их гүрнүүд цэрэг улс төрийн хэт амбицтай байсан нь хойд, урд хөршийн гадаад, дотоод улс төрийн байдлыг мөн тогтворгүй болгож байлаа.

Тэнхлэгийн хүчнүүд гэгдэх Япон, Герман, Итали улсууд дэлхийн I дайны дараах Версалын гэрээнд эгдүүцэн дараагийн цэрэг-улс төрийн ажиллагаанд бэлдэж эхэлсэн байна. Азид Японы имперлистууд хүчээ авч эзлэн түрэмгийлэх бодлогоо эрчимтэй хэрэгжүүлж 1931 онд Хойд Хятад, Өвөр Монголыг эзлээд зогсохгүй 1932 оны 3 дугаар сарын 1-нд Манж Го улсыг байгуулсан төдийгүй ‘Япон нь Монгол мэтийн хоёрдмол бүхий нутаг дэвсгэрийг өөрийн нөлөөний бүстэй шууд хил залгаа байлгахыг хүсэхгүй’ хэмээн эзлэн түрэмгийлэх бодлогыг шууд илэрхийлж эхэлсэн байдаг. Харин Европт фашистын Герман, Адолф Гитлерын түрэмгий бодлого эрчимжиж, Төв болон Зүүн Европ руу чиглэсэн цэрэг улс төрийн ажиллагаагаа эхлүүлсэн. Мөн Хятадын дотоод болон гадаад байдал тогтворгүй байлаа. Энэ байдал нь Монголын гадаад бодлогод хүчтэй нөлөөлж тухайн үед улс төрийн хувьд хойд хөршийг түшихээс өөр аргагүйд хүргэсэн байдгаараа хоёр орны дипломат харилцаа онцлогтой байдаг.

И.Сталин тэргүүтэй Зөвлөлтийн удирдагчид тухайн үеийн цэрэг улс төрийн байдлыг үнэлэн өрнөдөд Польшийн талаас, Дорнодод Японы зүгээс ЗХУ-ын эсрэг халдлага гарч болзошгүй байгаад анхааран 1932 онд Бүх холбоотны коммунист намын Улс төрийн товчооны дэргэд “Монголын Комисс”-ыг байгуулж батлан хамгаалах асуудалд шууд оролцох болсон. Монголын Комисс нь Улс төрийн товчоо, Т.Сталины шууд удирдлагаар 1939 оны 3 дугаар сар хүртэл ажиллаж БНМАУ-ын талаарх худалдаа, эдийн засаг, тээвэр, батлан хамгаалахын бүхий л асуудлыг шийдэж байсан. 1932-1934 онд Комисс 1932 оны зэвсэгт бослогын үр дагаварыг арилгах зорилгоор БНМАУ-ын дотоод улс төр, бараа таваарын хангамжийг тогтворжуулахад онцгой анхаарч байсан бол 1935 оноос Япон Манжгогийн зүгээс нэмэгдсэн хилийн будлиан түрэмгий үйлдлүүдтэй уялдан БНМАУ-ын дотоод улс төр, батлан хамгаалах асуудалд анхаарч байсан. 1934 онд байгуулсан хоёр орны Харилцан туслалцах хамтын ажиллагааны аман гэрээг 1936 оны 3 дугаар сарын 12-нд дахин батлагаажуулж “Харилцан туслалцах протокол” гэрээг байгуулсан байдаг. Уг гэрээний 1 ба 2 дугаар зүйлд зааснаар ‘Тэрээ байгуулж байгаа 2 этгээд хэрэв ямар нэг гуравдагч этгээдийн зүгээс ЗСБНХУ буюу БНМАУ-ын нутаг дэвсгэрт довтолох аваас бие биедээ аливаа тусламж, түүний дотор цэргийн тусламж үзүүлэх явдлыг харилцан үүрэг болгон авч байна’ гэж тусгасан байна.

1939 онд БНМАУ-ын дорнод хязгаар Халхын голд Японы Квантуны арми довтолж БНМАУ-ын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд аюул тулгарсан. Энэ дайнд Монгол Зөвлөлтийн цэргийн хамтарсан хүчин ялалт байгуулсанаар хоёр улс харилцаа хамтын ажиллагаагаа улам бүр өргөжүүлсэн. Ийнхүү ЗХУ болон БНМАУ-ын харилцаа нь хоёр орны засгийн газрын үзэл суртлын нэгдмэл байдлаас гадна Алс Дорнодод улам бүр заналхийлэх аюулын эсрэг үндэсний эрх ашгаар нэгдэн нийлж гадаад аюулгүй байдлаа хангах гэсэн бодлогын үр дүн болж хэрэгжсэн.

Үүний томоохон нэг жишээ бол БНМАУ-ын нам, засгийн удирдлагаас 1941 оны 6 дугаар сарын 22-нд ЗХУ-д фашист Герман халдан довтолсоныг эсэргүүцэж Зөвлөлтийн Улаан Армид бүхий л талаар туслан дэмжихийг илэрхийлж “тус орны аж ахуй ба батлан хамгаалах хэргийг хөгжүүлэх” -ийг онцлон тэмдэглэсэн. МАХН-ын Төв хорооны 1941 оны 11 дүгээр сарын бүгд хурлаас “Фашист Германиудаас ЗХУ-д халдан довтолсон нь өөрийн аж ахуй, улс төр, соёл боловсролын бүх байдалд ЗСБНХУ-ын ах дүүгийн тусламжийг түшиглэж буй БНМАУ-ын төрөлхийн мах цусны эрх ашигт шууд халдлага хийсэн хэрэг болно. Зөвлөлтийн ард түмэн нь...Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтносон байдлыг хамгаалж байна” гэж үзсэн байна. Эл шийдвэрийн дагуу улс орон даяар ‘Бүхнийг фронтод’, ‘Бүхнийг ялалтын төлөө’ гэсэн уриан дор Зөвлөлтийн ард түмэн, Улаан армид туслах хөдөлгөөн газар сайгүй өрнөж Улаан армид зориулан Монголын ард түмний хүч хөрөнгөөр ‘Хувьсгалт Монгол’ танкийн цуваа, ‘Монгол ард’ нисэх эскадриль байгуулж шилжүүлсэн ба дайны жилүүдэд 32 мянга гаруй агт морь бэлэглэж хагас сая шахам морьд худалдсан байна. Мөн Улаан армид зориулан 8 удаа галт тэрэгний 11 цуваа бэлэг явуулсан нь нийтдээ 438 сая төгрөгнийг үнэ бүхий зүйл болсон байна. Дэлхийн II дайн 1945 оны 5 дугаар сарын эхээр ЗХУ болон түүний холбоотнуудын ялалтаар дуусаж, БНМАУ-ын хувьд дээрх олон улсын болон бүс нутгийн асуудалд ЗХУ-ын цэрэг улс төрийн бодлого, байр суурийг баттай дэмжиж бүхий л тусламж дэмжлэгийг үзүүлж байсан нь өөрийн улс үндэстний тусгаар тогтнол, аюулгүй байдлаа батлан бэхжүүлэх алс хэтийн бодлого байсан юм.

Мөн түүнчлэн 1945 оны 2 дугаар сард Холбоотон гүрнүүдийн Ялтын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу ЗХУ Японд дайн зарлахад БНМАУ-ын Бага хурал мөн Японд дайн зарлаж Сахалин, Курилын аралд байсан Японы цэргийн хүчийг бут цохиж, Манжуур, Солонгост байсан Японы эдийн засгийн баазыг булаан эзэлж Японыг буулган авахад Чөлөөлөх дайнд ЗХУ-ын цэргийн хүчинтэй хамтран зүтгэсэн байдаг. Энэ нь цаашид олон улсын тавцанд өөрийн нэр нөлөө байр сууриа бэхжүүлэх, ЗХУ-ын удирдлагаар дамжуулан хэлэлцээр хийж Хятадын эрх баригчидар БНМАУ-ын төрийн тусгаар тогтнол, бие даасан бүрэн эрхийг хүлээн зөвшөөрүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх нэг чухал хүчин зүйл болж чадсан юм.

Монгол Зөвлөлтийн 1936 оны харилцан туслалцах протоколын үйлчлэх хугацаа дуусч 1946 оны 2 дугаар сарын 27-нд БНМАУ ба ЗХУ-ын хооронд Найрамдал, хамтын ажиллагааны Гэрээг байгуулсан. Уг гэрээгээр ‘БНМАУ

буюу Зөвлөлийн засагт Нийгэм журамт Бүгд Найрамдах Холбоот улсын нутаг гуравдагч улсын зүгээс довтлох аюул тохиолдвол БНМАУ буюу Зөвлөлийн засагт Нийгэм журамт Бүгд Найрамдах Холбоот улсын засгийн газрууд нь тохиолдсон байдлыг нэн даруй хамтран хэлэлцэж тус хоёр улсын нутаг дэвсгэрийг тэрхүү аюулаас хамгаалахад хэрэглэгдэж болох бүх арга хэмжээг авах үүргийг тус тусдаа хүлээнэ” гэж үзсэн заасан байдаг. Мөн БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд эдийн засгийн хамтын ажиллагаанд гарын үсэг зурсан нь эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, МАХЦ-ийг шинэчлэх, түүний чадавхийг бэхжүүлэх чухал хүчин зүйл болсон байдаг.

1946 оноос БНМАУ-ын Загийн газар НҮБ-д гишүүнээр элсэх өргөдөлөө удаа дараа илгээсэн боловч 1961 оныг хүртэл НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн хуралдааны саналын хувь хүрэхгүйгээр удаа дараа түдгэлзүүлж байлаа. Түдгэлзэж байсан улсын нэг бол Франц улс байсантай холбоотойгоор 1960 онд Франц Мавритинийг НҮБ-ын гишүүн болгохоор оруулсан саналын төсөлд ЗХУ-ын НҮБ дахь төлөөлөгч В.Зорин ‘хэрэв БНМАУ-ыг элсүүлэх асуудалд нааштай хандвал Мавритиний асуудалд хориг тавихгүй гэж байр сууриа илэрхийлсэн байдаг. Ингээд 1961 оны 10 дугаар сарын 27-ны өдөр НҮБ-ын Ерөнхий ассемблейд БНМАУ-ын НҮБ-ын гишүүнээр элсүүлэх тухай Аюулгүйн зөвлөлийн тогтоолын дагуу бүх гишүүн улсын нэрийг дуудах журмаар санал хураалт болсоноор гишүүн улс болгон баталсан байдаг.

Ийнхүү 1961 онд НҮБ-ын гишүүн болсоноор олон улсын тавцанд Монгол Улсын нэр хүнд өсөж, одоо ч гадаад харилцаа өргөжин тэлэх боломжийг бүрдүүлсээр байна.

1964 онд БНХАУ цөмийн зэвсэгтэй болсоноо зарласан төдийгүй ЗХУКН болон ХКН-ын хооронд үзэл суртлын зөрүүтэй байдал бий болон гүнзгийрч хоёр хөршийн харилцаа илт муудаж эхлэхэд ЗХУ Монголын нутаг дэвсгэр дээр цэргийн томоохон нэгтгэлүүдийг байрлуулсан байдаг. Ингээд 1990 оныг хүртэл Монгол Улс үндэсний аюулгүй байдлаа холбоотны аргаар хангаж ЗХУ-ыг түшиглэж, цэрэг батлан хамгаалах бодлогын асуудалд түлхүү анхаарч байсан нь зөв алхам байсан гэж үзэж байна. Зөвлөлтийн цэрэг нь Монголын нутаг дэвсгэрт 1921, 1939, 1945 ба 1967 онуудад 4 удаа орж байрлаж байсан нь Монгол Улсын эсрэг гадны халдлагыг зогсоох болон болзошгүй дайсны эсрэг ЗХУ болон Монгол орныг батлан хамгаалах зорилготой байсан гэж үздэг байна.

1980 оны сүүлч 1990 оны эхэн үед ЗСБНХУ (хуучин нэрээр)-д улс төрийн үйл явц өрнөж, өөрчлөлт шинэчлэл явагдсаны үрээр холбооны улсуудад задрал явагдаж, 1991 онд ОХУ дангаараа тусгаар улс болсон билээ. Ийм учраас 1990-ээд оноос хойш ОХУ болон Монгол Улсын батлан хамгаалах салбарын харилцаа, цаашдын төлөвийн талаар энэхүү сэдвээр хөндөнө.

ОХУ-тай Монгол Улс цэрэг-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр 1993 онд байгуулагдсан хэдий ч улс төр эдийн засгийн тогтолцооны шилжилтийн үеийн хүнд байдлыг даван туулах, дотоодын асуудлаа шийдвэрлэх зэрэг олон хүчин зүйлээс

шалтгаалан хоёр улсын батлан хамгаалахын салбарын харилцаа тийм ч эрчимтэй хөгжиж чадаагүй.

ОХУ-ын аюулгүй байдлыг хангах салбаруудын нэгэн тулгуур болох батлан хамгаалах салбар “Батлан хамгаалах бодлого 2021-2025” (План обороны Российской Федерации на 2021-2025 годы) бодлогын баримт бичиг 2020 оны 11 дүгээр сарын 13-нд ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин баталсан байна. ОХУ-ын 2016-2020 оны батлан хамгаалах бодлого нь стратегийн цөмийн зэвсгийн чадавхыг нэмэгдүүлэх болон цэргийн баруун тойргийн үйл ажиллагааг сайжруулахад оршиж байсан бол 2021-2025 оны шинэчилсэн бодлогод зарим чиглэлүүдийг нэмэлтээр тодорхойлсон байна.

Энэхүү бодлогын баримт бичиг бүрэн эх хувилбараараа олон нийтэд мэдээлэгдэж илт болоогүй хэдий ч зарим цэргийн шинжээчид болон албаны хүмүүсийн хэвлэл, мэдээлэл, хурал, цуглаан дээрх илтгэлүүдээс судлаачид уг баримт бичигт ОХУ-д тулгарч болох гадны аюул заналхийлэл, Оросын зэвсэгт хүчнийг хөгжүүлэх стратегийн чиглэл, цэргийн зэвсэглэлийн талаарх бодлого, орон нутгийн хамгаалалт болон дайчилгаатай холбоотой бодлогыг боловсронгуй болгох зэрэг өргөн хүрээтэй асуудлыг тодорхойлсон гэж үзсэнийг дараах байдлаар нэгтгэн тоймлож байна. Үүнд:

Нэгд, стратегийн цөмийн зэвсэг, сансар болон кибер орон зайн чиглэлээр үндэсний батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх;

Хоёрт, гадаад бодлогод дараах гурван чиглэлд анхаарах. Үүнд:

- Беларусьт үүсээд байгаа нөхцөл байдал, Молдовын шинээр сонгогдсон эрх баригчдын Оросын энхийг сахиулагчдыг эх орноосоо гаргахтай холбоотой асуудал, Өмнөд Кавказ дахь Турк улсын нөлөө нэмэгдэж буй байдал;
- Оросын стратегийн давамгайллын бүс гэгдэх Арктикийн бүс нутагт АНУ-ын болзошгүй заналхийлэл (Баренцын хоолойг боомилох цэг болгон хувиргах гэх мэт);
- Евразийн нутаг дахь зарим улс орнуудын сөргөлдөөнд (Хятад-Энэтхэг, Энэтхэг-Пакистаны мөргөлдөөн) энх тайваны зуучлагч болоход Оросын үүргийг нэмэгдүүлж олон улсын тавцанд өөрийн байр суурь, нэр хүндийг өсгөхөд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Гуравт, дэлхийн зэвсгийн зах зээл дээр Оросын өрсөлдөх чадварыг хадгалах, орчин үеийн дайны шинж чанар өөрчлөгдөж байгааг харгалзан цэрэг-техникийн шинэ шийдлүүдийг боловсруулах,

Дөрөвт, барууны орнуудын тавьж байгаа хориг арга хэмжээтэй холбоотойгоор эдийн засгийн салбарт импортыг орлох стратегийн бүтээгдэхүүн үйлчилгээний үр нөлөөг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

Тавд, “эрлийз сорилтууд” (hybrid challenges) гэж нэрлэгддэг терроризм, эсэргүүцлийн хөдөлгөөн зэрэгтэй тэмцэх арга хэмжээ зэргийг багтаасан байна.

Үүнээс үзэхэд нэг талаар энэхүү бодлогын баримт бичиг цэрэг-улс төрийн, геополитикийн, гео-эдийн засгийн болон “эрлийз” (hybrid) гэсэн талбаруудад ОХУ-д тулгарч болзошгүй сорилт, бэрхшээлийг шийдвэрлэхэд батлан хамгаалах

салбарын бодлогыг тодорхойлсон нь илт байна. Нөгөө талаар цэрэг техникийн шинэчлэлийг тасралтгүй хийж, зэвсэглэлийн чадавхийг бэхжүүлж, ОХУ-ын стратегийн ашиг сонирхол бүхий газар нутагт НАТО-ын нөлөөг бууруулах, гадаад бодлогын хүрээнд бүс нутагт ОХУ-ын нөлөөг нэмэгдүүлэх, уламжлалт болон уламжлалт бус аюулгүй байдалтай холбоотойгоор дотоодын аюулгүй байдлыг хангахад Батлан хамгаалах стратегийг тусгасан чухал баримт бичиг байна.

Энэхүү бодлогын баримт бичгийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээнүүдийг өнөөдрийн олон улсад илтээр явуулж байгаа цэрэг стратегийн үйл ажиллагаа болох ОХУ-ын баруун хилийн дагуу болон “ойрын гадаад” хуучин холбооны улсуудтай хийж байгаа цэргийн хүчний дахин байршуулалт, хөдөлгөөн, байлдааны буудлагатай сургалт дадлага, Уулын Карабах дахь ажиллагаа зэргээс харагдаж байна.

ОХУ-тай Монгол Улс цэрэг-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр 1993 онд байгуулагдсанаас хойш зэвсэглэл техникийн тусламж, цэргийн боловсон хүчин бэлтгэх зэрэгт хамтран ажиллаж байна. Тухайлбал, ОХУ-аас манай Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийн шинэчлэлд зориулж танк, хуягт болон авто техник, агаарын довтолгооноос хамгаалахын цогцолбор, гүйцэтгэн цэнэглэсэн артиллерийн галт хэрэгслийг аюулгүй болгох байгууламж, нисдэг тэрэг, холбооны хэрэгсэл, тэдгээрийн сургалтын төхөөрөмж болон засварын цогцолборын хамт нийлүүлсэн. Мөн батлан хамгаалах, зэвсэгт хүчний удирдлага, төрлийн цэргүүдийн болон цэргийн боловсрол, эрдэм шинжилгээ, эмнэлэг, хүмүүнлэгийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.

Одоогийн байдлаар хоёр улсын батлан хамгаалах салбар дараах чиглэлийн хүрээнд хамтран ажиллаж байна. Үүнд:

- цэрэг-техникийн буцалтгүй тусламж үзүүлэх;
- боловсон хүчин бэлтгэх, сургах;
- хамтарсан цэргийн хээрийн сургуулилт хийх, туршлага судлах;
- эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр хамтран ажиллах;
- соёл, урлаг, спортын арга хэмжээнд оролцох;
- Халх голын дайн, Чөлөөлөх дайны, Аугаа Эх орны дайны түүхэн ойлголт хамтран тэмдэглэх зэрэг болон бусад чиглэлээр хоёр талын харилцаа хөгжиж байна.

2019 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Монгол Улсад айлчлах үеэр цэрэг-техникийн буцалтгүй тусламж үзүүлэх гэрээг 2023 он хүртэл сунгасан нь өндөр ач холбогдолтой үйл явдал болсон. ОХУ-ын үзүүлж ирсэн буцалтгүй тусламж нь манай улсын Зэвсэгт хүчний бэлэн байдал, чадавхид чухал ач холбогдолтой юм. Гадаадын улс орнуудаас үзүүлсэн буцалтгүй тусламжийг мөнгөн дүнгээр харьцуулах юм бол ОХУ бусад улсаас хол тасархай тэргүүлж байна. Монгол-Оросын батлан хамгаалах салбарын харилцаа 1990 оноос хойш хамгийн сайн үедээ хүрсэн гэж үзэж байна.

Оросын цэрэг батлан хамгаалах салбарын шинэчлэлийн хүрээнд дахин зохион байгуулагдсан цэргийн тойргуудтай Монгол Улс өөрийн цэрэг батлан хамгаалах салбарын эрх зүйн хүрээнд Зэвсэгт хүчний хамтын ажиллагааг идэвхжүүлэх зайлшгүй шаардлагатай юм. Ялангуяа энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр бүс нутагт болон олон улсад энх тайван байдлыг сахиулахад хамтран ажиллахад цэргийн хамтын ажиллагааг бэхжүүлэх нь олон талын ач холбогдолтой билээ. ОХУ-ын Засгийн газрын 2014 оны тайланд олон улсын тавцанд өөрийн нэр хүндийг бэхжүүлэх зорилгоор энхийг дэмжих ажиллагаанд ОХУ-ын улсын үүрэг ролийг нэмэгдүүлэх нь чухал болохыг тэмдэглэсэн байдаг. ОХУ энхийг дэмжих ажиллагаанд болон НҮБ-ын удирдах байгууллага, ялангуяа Энхийг сахиулах ажиллагааны газарт ахлах албан тушаал хашиж байгаа орос иргэдийн тоог нэмэгдүүлэхийг тэргүүлэх чиглэлээр тогтоосон. ОХУ НҮБ-ын ЭДА-г төлөвлөх, энхийг сахиулах шинэ ажиллагаа эхлүүлэх эсвэл одоо байгаа үйл ажиллагааг өргөтгөх зэрэг үйл ажиллагааны бүхий л шатны хэрэгжилтэд хатуу хяналт тавих шаардлагатай бөгөөд хариуцлагын системийг бий болгох асуудлыг илүүтэйгээр хөнддөг бөгөөд зарим тохилдолд ЭДА-ны чиглэлээр Аюулгүйн зөвлөлийн тогтоол дээр санал өгөхөөс татгалздаг. Тухайлбал хамгийн сүүлд Өмнөд Судан дахь UNMISS-ийн бүрэн эрхийг шинэчлэх тухай 2304 (2016) тогтоол, Баруун Сахар дахь MINURSO-гийн бүрэн эрхийг сунгах 2285-р тогтоолд санал өгөхөөс татгалзсан байна. Гэсэн хэдий ч одоогийн засгийн газар нь түүний хүчирхэг гүрэн болох дүр төрхийг баталгаажуулах, НҮБ-д шийдвэр гаргахад илүү их хяналт тавих, НҮБ-ын энхийн ажиллагаанд Оросын үүрэг ролийг нэмэгдүүлэх сонирхолтой байгаагаа байнга илэрхийлдэг. Гэхдээ НҮБ-ын энхийн ажиллагаанд илүү өргөн хүрээнд оролцох боломж байгаа хэдий ч ОХУ-ын өнөөгийн тулгамдаж буй гол бэрхшээл, Европын орнуудын хязгаарлалт, хориг, дотоодын эдийн засгийн чадавхиас шалтгаалж байна гэж үзэж байна. ОХУ нь Аюулгүй зөвлөлийн байнгын гишүүний нэг, НҮБ-ын санхүүжилтийг бүрдүүлэгч эхний 10 улсын нэг зэрэг нь олон улсын аюулгүй байдлын салбарт нөлөөлөх тодорхой байр суурийг эзэлж байгааг харуулж байна.

ОХУ-ын цэргийн хүчин 1973 онд Ойрхи Дорнод, 1990-ээд оны үед, Балкан, Ангол, Камбожид энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн байдаг. Сүүлийн жилүүдэд Голаны өндөрлөг, Ойрхи Дорнод, Молдав, Баруун Сахар, Бүгд Найрамдах Ардчилсан Конго, Кот д'Ивуар, Либери, Сири, Судан зэрэг улсад явагдаж байгаа НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа төдийгүй НҮБ-д хамгийн олон тооны цэргийн ажиглагчтай 10 орны тоонд багтаж байна. Мөн ОХУ энхийн ажиллагаанд гэрээт буюу агаарын тээврийн үйлчилгээ үзүүлдгээрээ хоёрт орж байна. 2020 онд Уулын Карабахад болсон зэвсэгт мөргөлдөөнийг зогсооход олон улсын төдийгүй бүс нутагтаа үндсэн тоглогч байж гурван талт гал зогсоох хэлэлцээрийг зохион байгуулснаар бие даан энхийг сахиулах хүчийг ажиллагааны газар оронд илгээгээд байна. Энэ нь нэг талаараа ОХУ бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангахад давамгайлах байр суурьтай байгааг харуулж байна.

Монгол Улсын хувьд 2011 онд “Гадаад бодлогын үзэл баримтлал”-аа шинэчлэн баталж, аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангах бодлогынхоо хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж, тодорхой амжилтанд хүрээд байна. Үүнд:

- Үндэсний аюулгүй байдлаа хангах гадаад таатай нөхцлийг бүрдүүлэх энх тайванч бодлогоо илэрхийлж “Цэргийн хүч хэрэглэх болон хэрэглэхээр заналхийлэхийг зөрчил, маргааныг шийдвэрлэх арга зам гэж үзэхгүй бөгөөд аливаа хүчирхийлэл, түрэмгийллийг үл зөвшөөрөх” гэж тунхагласан.
- Монгол Улсын өөрийгөө хамгаалах зарчимд нийцүүлэн “Гадны зэвсэгт түрэмгийлэлд өртөхөөс бусад тохиолдолд дайн, зэвсэгт мөргөлдөөнд оролцохгүй байх” гэдгээ албан ёсоор баталсан.
- Монгол Улс газар нутгаа цөмийн зэвсэггүй бүс гэж зарлаж, дэлхийн хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүний хувьд олон улсын эрх зүйн түгээмэл зарчмуудыг иш үндэс болгон “Үй олноор хөнөөх зэвсгийн тархалтыг хязгаарлах, олон улсын терроризмтой тэмцэх чиглэлээр НҮБ, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх”-ээ илэрхийлсэн.
- Бие даасан гадаад бодлогоо тууштай баримтлан “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд цэргийн аюул, заналхийлэл учирсан буюу учрах нь бодитой болсноос бусад тохиолдолд цэргийн аливаа эвсэл холбоонд нэгдэхгүй” гэдгээ зарласан.

Монгол Улсын Үндсэн хуулийн заалтын дагуу “Хууль гаргахгүйгээр гадаадын цэргийн хүчнийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх” гэдгээ дахин баталгаажуулсан. Гэхдээ эдгээр нь олон улсын энх тайван аюулгүй байдлын төлөө хөрш зэргэлдээ улс орнуудтай хамтран ажиллахад хязгаарлалт болохгүй гэж үзэж байна. Олон улсын аюулгүй байдлыг хангах хамгийн том байгууллагын нэг болох НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд хамтран оролцох нь НҮБ-ын гишүүн улсын хувьд манай хоёр орны хувьд чухал билээ.

Дүгнэлт

Монгол Улсын зэвсэгт хүчний нэг чухал чиглэл бол НҮБ-ын энхийг дэмжих болон бусад ажиллагаанд өөрийн оролцоог нэмэгдүүлэх явдал бөгөөд энхийг дэмжих ажиллагаанд оролцох нь олон улсын энхийн төлөөх үйлсэд хувь нэмрээ оруулж, Монгол Улсын нэр хүнд, байр суурийг бэхжүүлэх замаар аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангах төрийн гадаад бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, олон улсын хэмжээнд Монгол Улсын Зэвсэгт хүчнийг таниулж, нэр хүндийг өргөх, цэргийн алба хаагчдын мэргэжлийн бэлтгэл, ур чадварыг дээшлүүлэх, Зэвсэгт хүчний бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадварыг ахиулах, чухал ач холбогдолтой үйл ажиллагаа юм.

Монгол Улсын Зэвсэгт хүчин нь анх 2002 оноос хойших 19 жилийн хугацаанд НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын цэргийн ажиллагаанд давхардсан тоогоор нийт 19500 гаруй цэргийн алба хаагчийг оролцуулаад байна. Одоогоор Монгол Улсын Зэвсэгт хүчнээс БНӨСУ, Абей муж, Баруун Сахар, БНАКонгоУ, Йемэн зэрэг 5 улсын нутаг дэвсгэрт явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд штабын офицер, ахлагч-18, ажиглагч офицер-15, Өмнөд Судан Улсад /UNMISS/ ажиллагаанд цэргийн багийн-846 (Цэргийн багийн Х ээлжийн 639, XI ээлжийн 207), нийт 883 цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй биелүүлж байгаа бөгөөд Монгол Улс нь НҮБ-ын цэрэг хандивлагч орнуудаас эхний 24-т жагсаж байна.

НҮБ энхийн ажиллагаанд тухайн бүс нутгийн оролцоог түншлэлийн арга замаар нэмэгдүүлэх, оперативын болон тактикийн түвшний ажиллагаанд тэднийг түлхүү оролцуулах шинжтэй болж байна. Энэ нь их гүрнүүдийн ашиг сонирхолын зөрчилдөөнийг бууруулах давуу талтай хэдий ч тухайн бүсийн байгууллага дахь давамгайл улсын нөлөөлөлд аливаа шийдвэр гарах магадлалтай юм. Магадгүй ирээдүйд учирч болох хүн төрөлхтөний зөрчилдөөн бүс нутгуудын ашиг сонирхол, үзэл бодол, шашин шүтлэгийн гадуурхал, давуу байдал зэргээс үүдэхийг үгүйсгэхгүй юм.

Иймд олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад НҮБ бүс нутгийн болон дэд бүсийн байгууллагуудын энхийн ажиллагааны оролцоо, эрх, үүрэг, болон хариуцлагын талаарх эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох, бүс нутгийн орнууд илүү ахисан түвшинд хамтарч ажиллах, өөрийн байр суурь, нөлөөллийг бүхий л талаар энэ түвшинд бэхжүүлэх нь хамгийн чухал юм. Тиймээс цаашид хоёр орны батлан хамгаалах салбарын харилцааг уламжлалт ажиллагаанаас гадна уламжлалт бус ажиллагаанд тэр дундаа энхийг сахиулах ажиллагааны талбарт өргөжүүлэх нь бүс нутагт төдийгүй олон улсад аюулгүй байдлыг хангах, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой